



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 4/329

Мөрөн сум

Инженерийн шугам сүлжээний ажлыг
ашиглалтад оруулах комисс
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.4, 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан Гэр хорооллын гадна инженерийн шугам сүлжээний ажлын 2,3,4 дүгээр багийн цэвэр усан хангамжийн ажлыг хэсэгчлэн хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Б.Энхжаргал
байгуулалтын

хэлтсийн

Гишүүд:

Х.Даваасүрэн

Р.Элбэг-Очир
М.Лянхуа
Т.Янжиндулам
М.Оюунчимэг
Ш.Баасанпүрэв
Д.Мягмарсүрэн

Ж.Жавзанпагма

Л.Бямбасүрэн

С.Мөнх-Эрдэнэ

(Газрын харилцаа, барилга хот
газрын Барилга хот байгуулалтын
дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө
оруулалтын хэлтсийн мэргэжилтэн,
ерөнхий архитектор)

Мөрөн сумын Засаг даргын орлогч
Мөрөн сумын 2 дугаар багийн Засаг дарга
Мөрөн сумын 3 дугаар багийн Засаг дарга
Мөрөн сумын 4 дүгээр багийн Засаг дарга
Мөрөн сумын архитектор
(Газрын харилцаа барилга хот
байгуулалтын газрынБарилга техник
хяналтын улсын байцаагч)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн
дарга)

(Онцгой байдлын газрын Гамшгаас
хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч,
хошууч)

(Мөрөн хот тохижилт үйлчилгээний төвийн
захирал)

671 1010000

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Ж.Ганболд

(“Монкузбасс”ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

М.Алтанхуяг

(“Мон-энержи корпораци”ХХК-ийн ерөнхий инженер)

Ц.Баярмагнай

(“Мөнх Чандмань илч”ХХК-ийн захирал)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Д.Сүхээ

(Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)

Комиссын нарийн бичгийн дарга:

Д.Нямбат

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Инженерийн шугам сүлжээний ажил хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 2023 оны 7 дугаар сарын 20-ний өдрийн дотор зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Инженерийн шугам сүлжээний ажил хүлээн авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Д.Нямбат) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР